



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/380

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2 дахь, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард улсын Бээжин, Ченду, Чунчинг хотноо зохион байгуулах “Хөгжиж буй орнуудын мэдрэл, тархины судасны өвчний хяналт” сэдэвт 1 сарын сургалтанд оролцох Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн их эмч Д.Даваасүрэнд 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан “Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах чиглэлээр хөрш зэргэлдээ улс болон бусад улсын Эрүүл мэндийн байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах” зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ